



## НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 11 сарын 27 өдөр

Дугаар А/65


Улаанбаатар хот

### Нийслэл, дүүргийн оны “Тэргүүний биеийн тамирын хамтлаг” шалгаруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2009 оны 05, 2017 оны 289 дүгээр тогтоолууд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг даргын 2006 оны 165 дугаар захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:


1. Нийслэл, дүүргийн Нутгийн захиргааны байгууллагуудын дэргэдэх Биеийн тамирын хамтлагуудын үйл ажиллагааны тайлан үр дүнг үндэслэн Нийслэл, дүүргийн 2018 оны “Тэргүүний биеийн тамирын хамтлаг”-уудыг шалгаруулсугай.
2. Нийслэл, дүүргийн 2018 оны “Тэргүүний биеийн тамирын хамтлаг”-уудын шагналын төсвийг хавсралтаар баталсугай.
3. Шагналд шаардагдах 4.600.000 /дөрвөн сая зургаан зуун мянган/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны биеийн тамир, чийрэгжүүлэлтийн нийтийг хамарсан арга хэмжээний төсвөөс гаргахыг нягтлан бодогч /Л.Төгөлдөр/-д зөвшөөрсүгэй.
4. Шалгаруулалтын арга хэмжээг зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг Нийтийн биеийн тамирын хөгжлийн хэлтэс /А.Болдмаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны  
даргын 2018 оны...*11 дүгээр*... сарын *17*-ны өдрийн  
*А.65.* дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Нийслэл, дүүргийн 2018 оны "Тэргүүний биеийн  
тамирын хамтлаг" шалгаруулах төсөв

№	Зардлын нэр	Шагнал /төг/	Дүн /төг/
1.	Нийслэл, дүүргийн оны тэргүүний биеийн тамирын хамтлаг	1-р байр	1000.000
		2-р байр	800.000
		3-р байр	1.800.000
2.	Цом, өргөмжлөл	1000.000	1000.000
<b>ДҮН</b>		<b>4.600.000</b>	<b>4.600.000</b>